



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/773

Улаанбаатар хот

**Тээврийн хэрэгсэл балансаас
балансад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Багануур дүүргийн 5 дугаар хорооны “Ач элбэрэл” өрхийн эрүүл мэндийн төв, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн балансад тус тус бүртгэлтэй, нийт 670,796,112 (зургаан зуун далан сая долоон зуун ерэн зургаан мянга нэг зуун арван хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 3 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг эзэмшигч байгууллагуудын удирдлагуудад зөвшөөрсүгэй.

2.Хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг бүртгэн авч ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг тээврийн хэрэгслүүдийг шилжүүлэн авч буй байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020003760



Нийслэлийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 03-ны өдрийн
1999 дугаар захирамжийн
хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

№	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2022.04.30-ны байдлаар/	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Бага оврын автобус	Hyundai starex	37-53 УНО	KMJWA37JABU 325255	2010	31,941,135	31,941,135	0	Багахангай дүүргийн ЗДТГ	Багахангай дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв
2	Суудлын автомашин	Приус-30	66-05 БРА	ZVW305368621	2011	19,700,000	5,745,833,45	13,954,166.55	Багануур дүүргийн 5-р хорооны "Ач-элбэрэл" ӨЭМТ	Багануур дүүргийн 2, 4-р хорооны "Энх-Өрх" ӨЭМТ
3	Ээлжийн бүрэлдэхүүн тээвэрлэх автомашин	MAZ BA 6317	55-49 УАТ	Y396317F4L001 8012	2020	559,154,977	46,596,248.1	512,558,728.9	Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
Дүн						670,796,112				